



Баримтын төрөл: Ажлын даалгавар

Ажлын нэр: Байгаль орчны аудит хийлгэх

Огноо: 20200521

Боловсруулсан хэлтэс: БОУБ-ын хэлтэс

Зориулалт: Худалдан авалтын захиалгын хуудас № хавсралт

1. Тодорхойлолт:

Байгаль орчны аудит гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг хэлнэ.

Байгаль орчны аудит нь тухайн байгууллагын байгаль орчинд учруулж болох аливаа сөрөг нөлөө, хохирол, үр дагаврыг арилгах арга хэмжээг авах, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын экологи эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх, улмаар байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд туслах, тэднийг учирч болох алдагдал, хохирлоос сэргийлэхэд чиглэдэг.

2. Зорилго:

Байгаль орчны бүрдэл хэсгүүд болох ус, хөрс, агаар, биологийн төрөл зүйл, нөхөн сэргээлт, хог хаягдал, хими-аюултай бодис, байгаль орчны удирдлага-зөхион байгуулалтын бүх асуудлыг үндэсний хууль тогтоомжийн хүрээнд нарийвчлан шалгуулж, аливаа үл нийцэл илэрсэн тохиолдолд түүнийг сайжруулах мэргэжлийн зөвлөгөө авах.

3. Ажлыг гүйцэтгэх хугацаа, хамрах хүрээ:

- Аудит хийгдэх хугацаа 7- 14 хоног
- Байгаль орчны дэлгэрэнгүй аудит

4. Баримтлах хууль, эрх зүй

- Байгаль хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйл, Байгаль орчны аудит
- Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал: Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

5. Гүйцэтгэх ажлын үндсэн чиглэл:

- Аудит хийлгэгчийн удирдлагын систем буюу түүний зарим хэсэг нь аудитын шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох
- Төрийн бодлого, хууль тогтоомж, стандартын хэм хэмжээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тавигдсан шаардлагын биелэлтийг хангахын тулд удирдлагын тогтолцооны чадавхийг үнэлэх
- Тодорхой зорилгод хүрэхэд удирдлагын тогтолцооны үр нөлөөг үнэлэх

- Удирдлагын тогтолцоог сайжруулах боломжтой хэсгийг тодорхойлох

6. Гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага:

- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн дугаар А-126 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу аудит хийх эрх авсан байх,
- Аудитын багийн 2/3 доошгүй хувь нь байгаль орчны эрх бүхий аудитор байх.
- Байгаль орчны аудитын багийн ахлагч болон гишүүд нь БОННУ-ний эрх бүхий аж ахуйн нэгжид хавсран үүрэг гүйцэтгэдэггүй байх

7. Гарах үр дүн:

- Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй байгаль орчны хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, бодлогын бичиг Лиримт, БОННУ-ний хоронжилтийг уурхайн үйл ажиллагаатай уялдуулан дүгнэх,
- Орхигдолыг илрүүлж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, зөвлөмж боловсруулах,
- Аудитын дүгнэлт гаргах

8. Тайлагнах:

- Аудитын ажлын үр дүнг ажил эхэлснээс хойш 60 хоногт багтаан захиалагч талд танилцуулах,
- Албан ёсоор баталгаажсан аудитын дүгнэлт (1), зөвлөмжийг (2) хэвлэмэлээр хүлээн авах ба мөн (.doc) өргөтгөлтэй файлаар (CD/DVD) авна.
- Хураангуй тайпан англи хэл дээр захиалагч талд хүлээлгэн өгөх